




ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР


Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан




Макро эдийн засгийн бодлого



Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого



Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого



Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого



Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад болон батлан хамгаалах салбар

Төлөвлөлт оновчгүй, санхүүжилт бүрэн хийгдээгүйгээс үндсэн чиглэлийн хэрэгжилт хангалтгүй байна



YAГ-ГАГ/2017/01-ГА

АГУУЛГА

Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын газар

Газрын дарга, тэргүүлэх аудитор:

М.Давааням

Чиглэлийн аудитын алба:

Аудитын менежер:

Д.Баттулга

Ахлах аудитор:

Ж.Эрдэнэ
Б.Болормаа

Аудитор:

М.Доржмаа

Шинжээчид:

С.Одонцэцэг
Ш.Наранбаатар
Г.Мөнхчимэг
И.Туяадарь

Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 262451 дугаарын утсаар харилцана уу. Аудитын тайланг YAГ-ын www.audit.mn цахим хуудаснаас үзнэ үү.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160

Товчилсон үгийн жагсаалт	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
Аудитын тайлангийн хураангуй	5
Бүлэг 1. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг бодитой төлөвлөөгүй байна	6
<ul style="list-style-type: none"> • Үндсэн чиглэлийн зарим арга хэмжээний хүрэх түвшинг оновчтой тодорхойлоогүй байна • Өмнөх оноос шилжиж ирсэн арга хэмжээг үргэлжүүлэн төлөвлөхдөө хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг өөрчлөөгүй байна • Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцож, төлөвлөөгүй байна 	6 8 9
Бүлэг 2. Зарим байгууллагууд үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна	11
<ul style="list-style-type: none"> • Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зарим яам, агентлаг үр дүнтэй зохион байгуулаагүй байна • Үндсэн чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлсэн хөрөнгө нь зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрэлцээгүй байна • Зарим зорилт, арга хэмжээний өмнөх онуудад зарцуулсан хөрөнгө үр дүнгүй байна 	13 14 16
Бүлэг 3. Зарим хариуцан хэрэгжүүлэгч байгууллага үндсэн чиглэлийн арга хэмжээг бодитой үнэлж, тайлагнаагүй байна	17
<ul style="list-style-type: none"> • Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ холбогдох заалтыг баримтлаагүй байна • Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна 	17 18
Аудитын дүгнэлт	19
Аудитын зөвлөмж	20
Холбогдох байгууллагын санал	21
Саналд өгсөн тайлбар	22
Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал	23
Хавсралт №1. Үндсэн чиглэлийн дутуу хэрэгжсэн зорилт, арга хэмжээний жагсаалт	24
Хавсралт №2. Үндсэн чиглэлийн хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний жагсаалт	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГТБҮ	Газрын тос боловсруулах үйлдвэр
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УЦС	Усан цахилгаан станц
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ХШУДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ЭЗХГАХХ	Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд аудит хийв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлт оновчтой эсэх,*
- *Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг үр нөлөөтэй зохион байгуулсан эсэх,*
- *Үндсэн чиглэлийн биелэлт, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж, үр дүнг бодитой үнэлсэн эсэх.*

Улсын Их Хурлын 2015 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан байна. Нийт 158 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагуудаар Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлсэн болно.

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журам болон дараах арга зүйг ашиглав.

- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан тайланг судлах,*
- *Хөрөнгийн эх үүсвэрийг гүйцэтгэлтэй харьцуулах,*
- *Хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийж, тайлбар, тодруулга авч, мэдээлэл гаргуулах,*
- *Яамдын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэсийн үнэлгээний тайланг судлах,*
- *Үндэсний статистикийн хорооноос гаргасан эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг судлах,*
- *Цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийж, мэдээллийн эх үүсвэртэй тулгах,*
- *Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмын шалгуурыг баримтлах,*
- *Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг судлах.*

Гүйцэтгэлийн аудитын стандарт, журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг гүйцэтгэлийн аудитын журмын 8.9.10 дугаар маягтын дагуу бэлтгэж, ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын тайлангийн хураангуй

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7¹, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7², Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2³ дахь заалтыг тус тус үндэслэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг боловсруулсан байна.

УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд /цаашид Үндсэн чиглэл гэх/ дараах 5 бүлгийн хүрээнд 22 зорилт нийт 158 бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Үүнд:

- *Макро эдийн засгийн бодлого*
- *Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого*
- *Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого*
- *Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого*
- *Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого*

Үндсэн чиглэлийн нийт 158 арга хэмжээнд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогоос 29, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 119, бусад бодлогын баримт бичгээс 10 арга хэмжээ тусгагдсан байна.

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 233.9 тэрбум, орон нутгийн төсвөөс 0.7 тэрбум, Хөгжлийн банкны санхүүжилтээр 110.0 тэрбум, гадаад эх үүсвэрээс 278.0 тэрбум, ТХХТ-ийн 3,189.0 тэрбум, ХЭДС-гийн 7.0 тэрбум, хувийн хэвшлийн 2.5 тэрбум, холимог эх үүсвэрээс /Хувийн хэвшил болон гадаад эх үүсвэрээс 14.0 тэрбум, Хөгжлийн банк болон гадаад эх үүсвэрээс 15.7 тэрбум, Улсын төсөв болон гадаад эх үүсвэрээс 1.5 тэрбум/ 31.2 тэрбум нийт 3,852.3 тэрбум төгрөг төлөвлөгдсөн байна.

Үндсэн чиглэлийн арга хэмжээнд урьдчилсан гүйцэтгэлээр нийт 416.2 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 9 дахин бага бөгөөд зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн нөөц хангалтгүй байна.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, арга зүй, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан үнэлгээний журмын дагуу үнэлэхэд 158 арга хэмжээнээс хэрэгжсэн 55, хэрэгжилт дутуу 72, хэрэгжээгүй 31 дундажаар 58.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын дүнгээр 567.5 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, 2,567.0 сая төгрөгийн гэрээний үүргийг хугацаанд нь биелүүлээгүй нийт 3,134.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлагыг БСШУСЯ, УУХҮЯ-нд тус тус хүргүүлэв.

Аудитаар үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний үр дүнг сайжруулах 3, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж хэрэгжүүлэх 2, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох 1, хяналт тавих 1 нийт 7 зөвлөмжийг ТЕЗ, Сангийн яам, ЗГХЭГ-т тус тус өгөв.

¹ Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;

² Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, төсвийн хүрээний мэдээдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Хөтөлбөрт Засгийн газраас бүрэн эрхийнхээ хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжил, төрийн удирдлагын хүрээний асуудлаар хийж гүйцэтгэх ажлын гол зорилт, хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээг тодорхойлно. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд хөгжлийн бодлого, зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, тухайн жилд хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн томоохон арга хэмжээ, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдаа, хөрөнгийн эх үүсвэр, харууцан хэрэгжүүлэх яам, байгууллагыг тусгана.

³ Засгийн газар энэ хуулийн 8.2.1-д заасан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдээдэлд нийцүүлэн хянаж, Улсын Их Хуралд жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор өргөн мэдүүлэх;

Бүлэг 1. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг бодитой төлөвлөөгүй байна

1.1 УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон салбарын бусад бодлоготой уялдуулан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 5 бүлгийн хүрээнд 22 зорилт нийт 158 бодлогын арга хэмжээг баталсан байна.

1.2 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан байдлыг харуулбал,

Хүснэгт 1

Хөгжлийн бодлогын баримт бичгүүд	Арга хэмжээ	Хувь
Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого	29	18.4
Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр	119	75.3
Бусад бодлогын баримт бичиг	10	6.3
Нийт	158	100.0

1.3 Үндсэн чиглэлд тусгуулахаар яам, агентлагуудаас Сангийн яаманд нийт 440 зорилт, арга хэмжээний санал ирүүлснээс төсвийн байдал, бодлогын уялдаа зэргийг харгалзан 325-ыг хасч, 15-ыг нэмж нийт 130 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулжээ.

1.4 Үндсэн чиглэлийн төслийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны болон нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн 28 арга хэмжээ нэмэгдэж, нийт 158 бодлогын зорилт, арга хэмжээ баталсан байна.

1.5 Зорилт, арга хэмжээний тоо 2016 онд өмнөх оныхоос 67-оор нэмэгдсэн бөгөөд эдийн засгийн өсөлтийг дэмжих болон хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын хүрээний асуудал нийт арга хэмжээний 56.3 хувийг эзэлж байна.

Үндсэн чиглэлийн зарим арга хэмжээний хүрэх түвшинг оновчтой тодорхойлоогүй байна

1.6 2016 оны үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээний төлөвлөлтийг судлахад хүрэх түвшинг бодитой тодорхойлоогүй, санхүүжүүлэх эх үүсвэрийг заагаагүй зорилт, арга хэмжээ төлөвлөгдсөн байна. Тухайлбал,

Хүрэх түвшинг бодитой тодорхойлоогүй арга хэмжээнүүд:

- 2.6 “Үндэсний давхар даатгалын корпорацн байгуулах” хүрэх түвшин 100 хувь,
- 5.6 “Хоногт 2-5 тонн сүү хөргөх хүчин чадалтай хөргөлтийн төвүүдийг байгуулах” хүрэх түвшин 50 төв байгуулах,
- 8.2 “Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж ашиглалтад оруулах” хүрэх түвшин 189.5 км зам,
- 12.1 “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк байгуулах” хүрэх түвшин технологийн паркийн тоо 10,
- 13.2 “Хог хаягдлыг дахин боловсруулах, эрчим хүч, түүхий эд боловсруулах эко цогцолбор байгуулах” хүрэх түвшин байгууламжийн тоо 1.

Санхүүжүүлэх эх үүсвэрийг заагаагүй арга хэмжээнүүд:

- 2.6 ЭЗХГАХХ-ийн 11.3 дахь заалтыг хэрэгжүүлэхээр тусгасан “Үндэсний давхар даатгалын корпораци” байгуулж, давхар даатгалын хураамжийн гадагш урсгалыг бууруулах,
- 7.5 Эрчим хүчний эх үүсвэрүүдийг хангах зорилгоор “Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх”,
- 7.8 “Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгийн төвүүдэд дулаан хангамжийн шинэ эх үүсвэр барих”,
- 7.10 “Эгийн голын усан цахилгаан станц, түүний дэд бүтцийг барих ажлыг эхлүүлэх”,
- 10.3 “Монгол Улсын насанд хүрсэн иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагч нарт цахим гарын үсэг олгох”,
- 12.5 “Харилцаа холбооны үндсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох”,
- 17.4 “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх” гэх мэт.

1.7 Холбогдох байгууллагын саналд үндэслээгүй, УИХ-аар хэлэлцэх явцад дараах зорилт, арга хэмжээ батлагдсан байна. Үүнд,

УУХҮЯ:

- 5.7 “Цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар харилцагч талтай хэлэлцээр хийх, бодлогыг Улсын Их Хуралд танилцуулах”.

ЭХЯ:

- 5.8 “Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх”,
- 7.7 “Түлш, эрчим хүчний үнэ тарифыг зах зээлийн зарчмын дагуу бодит өртгийн тооцоонд үндэслэн зохицуулалт хийх”,
- 7.9 “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх”,
- 7.11 “БНХАУ-тай Эрчим хүчний ерөнхий хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлэх”.

ЗТХЯ:

- 8.8 “Даланзадгад Ховдын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгон өргөжүүлэх”,
- 8.9 “Ховдоос Завхан чиглэлийн Сархайрханы гүүр хүртэлх 130 км хатуу хучилттай авто замыг барих асуудлыг судалж шийдвэрлэх”.

ЗГХЭГ:

- 20.7 “Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны удирдлагын байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгож, давхардлыг арилгах, бодлогын нэгдмэл чанарыг хангах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах”.

Сангийн яам:

- 2.12 “Бизнесийн орчин, эдийн засгийн эрх чөлөөний, өрсөлдөх чадварын зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан индексээр Монгол Улсын өнөөгийн байр суурийг сайжруулах цогц төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх”,
- 20.8 “Төрийн захиалгаар гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн төлбөрийг тухайн санхүүгийн жилд багтаан гүйцэтгэж байх эрх зүйн орчныг сайжруулах”,
- 20.9 “Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг боловсронгуй болгох”.

ХХААХҮЯ:

- 2.11 “Үйлдвэрлэлийн орц болох эрчим хүч, материал, усыг үр ашигтай хэмнэлттэй болгох төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх”,
- 5.9 “Уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх, дэмжих үндэсний хөтөлбөрийг 2016 оны эхний хагас жилд багтаан боловсруулж батлуулах”,
- 12.6 “Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг хөгжүүлэх хүрээнд хоршоодыг дэмжиж бүх сумдад мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгох”,
- 12.7 “Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээр сэргээх, малын тэжээл бэлтгэх иргэдийн санаачилгыг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх”.

БОАЖЯ:

- 9.5 “Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт хийлгүүлэх”,
- 13.7 “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цоги, үр дүнтэй арга хэмжээ авах”.

ЭМЯ:

- 16.9 “Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тухай хууль гаргаж, төр, гэр бүл, иргэн бүрийн үүрэг хариуцлагыг сайжруулах”.

1.8 Арга хэмжээний бэлтгэл ажил хангагдаагүй, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаагүйгээс шалтгаалж дээрх ажлууд хэрэгжих үндэслэлгүй байна.

1.9 Үндсэн чиглэлд он дамжин хэрэгжих арга хэмжээний хэрэгжилтийг тухайн онд 100 хувь хэрэгжүүлэхээр төлөвлөж буй нь төлөвлөлт бодитой бус байгааг илтгэж байна. Тухайлбал,

- 2.7 “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг жигдрүүлж, эдийн засгийг дэмжих”,
- 5.2 “Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх”,
- 8.2 “Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж ашиглалтад оруулах”,
- 8.3 “Аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох” гэх мэт.

1.10 Дээрх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгийг бодитой төлөвлөж, тайлант жилд хүрэх түвшинг тодорхой зааж өгөх нь зүйтэй байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн арга хэмжээг үргэлжлүүлэн төлөвлөхдөө хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг өөрчлөөгүй байна

1.11 Үндсэн чиглэлд жил бүр төлөвлөгддөг боловч хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт өөрчлөгдөөгүй тодорхой үр дүнд хүрээгүй хэд хэдэн арга хэмжээ туссан байна. Үүнд:

Арга хэмжээний дугаар	Зорилт, арга хэмжээний нэр	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
3.3	“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг барьж байгуулах” /ШСАА/	Дэд бүтцийн ажлын явц, хувиар	50
5.2	“Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх” /УУХҮЯ/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр хүрэх түвшин, хувиар	100
8.5	“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1,2 дугаар үе шатны 1800 км төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх” /ЗТХЯ/	Тавантолгой-Сайншанд чиглэлийн /435 км/ Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн /430 км/ Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн /415 км/ Барилгын ажлын явц, хувиар	10
12.1	“Хөдөө аж ахуйн гаралтай түүхийг эдийг боловсруулах үйлдвэрлэл,	Байгуулах үйлдвэрлэл	10

	технологийн парк байгуулах” /ХХААХҮЯ/	технологийн паркийн тоо	
15.5	“Багануур дахь Их сургуулийн хотхоны дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх” /БСШУСЯ/,	Дэд бүтцийн барилгын ажлын явц, хувиар	5
21.2	“Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах” /ГХЯ/	Дэмжихээ илэрхийлсэн улсын тоо	2-оос доошгүй
21.3	“Зүүн Азийн дээд түвшний уулзалтын гишүүн улс болох чиглэлээр ажиллах” /ГХЯ/	Дэмжихээ илэрхийлсэн улсын тоо	2-оос доошгүй

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцож, төлөвлөөгүй байна

1.12 Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг өмнөх онуудтай харьцуулбал улсын төсвийн хөрөнгө буурч, ТХХТ-ийн хөрөнгөөр санхүүжих хэмжээ нэмэгдэж төлөвлөгдсөн байна. Хүснэгтээр үзүүлбэл,

Хүснэгт 2


Д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	2016	2015	2014	2013
1	Улсын төсөв	233.9	645.9	362.5	2,108.6
2	Зээл	-	66.0	516.6	-
3	Тусламж	-	8.0	-	-
4	Орон нутгийн төсөв	0.7	-	-	-
5	ТХХТ	3,189.0	100.0	-	697.0
6	Тусгай сан	-	25.0	-	-
7	ХЭДС	7.0	-	-	-
8	Хөгжлийн банк	110.0	-	-	-
9	Хувийн хэвшил	2.5	-	4.0	615.7
10	Гадаад эх үүсвэр	268.5	-	-	367.8
11	Холимог* эх үүсвэр	31.2	-	-	-
12	Бусад эх үүсвэр	-	320.0	-	116.7
	Нийт	3,852.3	1,164.9	883.1	3,905.8

* Хувийн хэвшил болон гадаад эх үүсвэрээс 14.0 тэрбум, Хөгжлийн банк болон гадаад эх үүсвэрээс 15.7 тэрбум, Улсын төсөв болон гадаад эх үүсвэрээс 1.5 тэрбум.

1.13 2016 оны үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн нийт эх үүсвэрийг өмнөх оныхтой харьцуулахад 2,687.4 тэрбум төгрөгөөр буюу 69.7 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Графикаар харуулбал,

График 1

/тэрбум төгрөг/



1.14 Зарим томоохон зорилт, арга хэмжээг ТХХТ-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тооцсон нь бодитой бус, нарийвчлан хийсэн тооцоо судалгаагүй байна. Тухайлбал,

- 3.3 “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг барьж байгуулахад 90.0 тэрбум төгрөг,
- 7.2 “ДЦС-5”-ын барилгын ажил, Сонгино дэд станц хүртэлх 220 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг эхлүүлж, дулаан дамжуулах магистраль шугамын зураг, төслийг боловсруулахад 150 сая ам.доллар,
- 7.3 Бүс нутгийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах хүрээнд Баруун болон Дорнод бүсийн ДЦС, Тавантолгой, Багануур, Тэлмэн, Баянтээгийн ДЦС-уудын барилгын ажлыг эхлүүлэхэд 250.0 сая ам.доллар,
- 8.5 Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэхэд 600.0 сая ам.доллар,
- 8.6 Эрдэнэт-Овоотын 3 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлүүлэхэд 131.0 сая ам доллар,
- 9.2 Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын нөөцийн агуулах барихад дэмжлэг үзүүлэх 19.0 тэрбум төгрөг,
- 13.2 Хог хаягдлыг дахин боловсруулах, эрчим хүч, түүхий эд боловсруулах эко цогцолбор байгуулах 300.0 тэрбум төгрөг гэх мэт.

1.15 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төслийн төлөвлөлтийг боловсруулахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, шаардагдах төсвийн эх үүсвэрийг бодитой тооцож, тайлант онд хэрэгжих үндэслэлтэй төлөвлөж байх шаардлагатай байна.

Бүлэг 2. Зарим байгууллагууд үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна

2.1 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг үнэлэхэд дундажаар 58.9 хувийн биелэлттэй байна. Бодлогын хамрах хүрээгээр харуулбал,

Хүснэгт 3

	Бодлогын хамрах хүрээ	Зорилт	Арга хэмжээ	Үнэлгээний хувь		
				Сангийн яам	ЗГХЭГ	ҮАГ
1	Макро эдийн засгийн бодлого	4	23	73.8	64.3	59.1
2	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	6	46	77.4	52.5	53.1
3	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	4	25	75.7	59.6	60.4
4	Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	5	43	75.6	67.9	68.1
5	Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	3	21	76.7	64.6	53.8
	Нийт арга хэмжээ	22	158			
	Дундаж үнэлгээ			75.8	61.8	58.9

2.2 Макро эдийн засаг болон эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудад хийгдэх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь экспортын гол бүтээгдэхүүний үнэ буурсан, гадаад валютын ханшийн өсөлт, импортын тоо хэмжээний бууралт зэргээс шалтгаалсан байна. Тухайлбал,

- Гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 2016 оны 12 сард 2,482.7 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 486.7 төгрөгөөр буюу 24.4 хувиар суларсан байна.
- Дэлхийн банкны 2016 оны мэдээгээр төмрийн хүдэр өмнөх оноос 5.8 ам.доллараар, нүүрс 6.5 ам.доллараар, зэс 860.5 ам.доллараар, түүхий нефьт 7.8 ам.доллараар тус тус буурсан байна.
- 2016 оны 12 дугаар сарын байдлаар нийт импортын хэмжээ 3.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 439.6 ам.доллараар буюу 14.8 хувиар буурсан байна.

2.3 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд батлагдсан макро эдийн засаг, төсөв, мөнгөний бодлогын голлох арга хэмжээний урьдчилсан гүйцэтгэл хангалтгүй үзүүлэлттэй байна. Хүснэгтээр үзүүлбэл,

Хүснэгт 4

Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү
Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт, хувиар	5.0	1.3	1.0	-0.3
Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам.доллар	4400.0	-	3567.3	-832.7
Ажилгүйдлийн түвшин, хувиар	7.0	-	8.6	1.6
ДНБ-д нэгдсэн төсвийн орлогын эзлэх доод хэмжээ, хувиар	24.6	13.9	22.6	8.6
ДНБ-д нэгдсэн төсвийн зарлагын эзлэх дээд хэмжээ, хувиар	28.6	42.2	40.1	-2.1
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлийн ДНБ-д эзлэх хэмжээ, хувиар	-4.0	-	-18.0	-14.0

2.4 2016 оны хэрэгжилтийг 2015 оныхтой харьцуулбал арга хэмжээний тоо 67 арга хэмжээгээр нэмэгдсэн бөгөөд хэрэгжилтийн дундаж үнэлгээ 58.9 хувь болж 11.1 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 5

Зорилт, арга хэмжээ	2016		2015		2014		2013	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	Хувь
Хэрэгжсэн	55	34.8	45	49.4	32	30.7	55	11.7
Хэрэгжилт дутуу	72	45.6	35	38.4	62	60.3	101	82.8
Хэрэгжээгүй	31	19.6	11	12.2	10	9.0	10	5.5

2.5 Үндсэн чиглэлийн 158 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 55, хэрэгжилт дутуу 72, хэрэгжээгүй 31 байгаа ба Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын дагуу хариуцан хэрэгжүүлэгч байгууллагаар зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг ТЕЗ, Сангийн яам, ҮАГ тус тус үнэлснийг хүснэгтээр харьцуулан харуулбал,

Хүснэгт 6


Д/д	Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд	Арга хэмжээний тоо	Хүрсэн түвшинд өгсөн үнэлгээ /хувиар/			Хэрэгжилт /тоогоор/		
			ТЕЗ	Сангийн яам	ҮАГ	Хэрэгжсэн*	Хэрэгжилт дутуу**	Хэрэгжээгүй***
1	Сангийн яам	13	78.5	74.6	68.4	6	7	-
2	Зам, тээврийн хөгжлийн яам	9	77.9	76.3	21.0	1	1	7
3	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	9	80.8	64.4	56.6	4	3	2
4	Батлан хамгаалах яам	2	96.0	100	100	2	-	-
5	Барилга, хот байгуулалтын яам	5	87.5	97.5	78.0	4	-	1
6	Гадаад харилцааны яам	8	91.2	87.1	61.2	3	4	1
7	Эрүүл мэндийн яам	9	90.0	87.8	78.9	5	4	
8	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	17	80.9	72.4	62.1	3	12	2
9	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	20	76.8	75.0	68.5	7	11	2
10	Хууль зүй, дотоод хэргийн яам	7	68.3	70.0	37.1	1	4	2
11	Эрчим хүчний яам	12	91.8	73.3	51.0	3	6	3
12	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	11	84.2	77.3	60.6	3	6	2
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	21	76.7	72.9	53.3	7	8	6
14	Санхүүгийн зохицуулах хороо	1	60.0	50.0	50.0	-	1	-
15	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар	1	90.0	90.0	90.0	1	-	-
16	Шадар сайдын ажлын алба	1	70.0	70.0	70.0	-	1	-
17	Онцгой байдлын ерөнхий газар	4	90.0	90.0	90.0	3	1	
18	Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар	3	66.7	60.0	10.0	-	1	2
19	Үндэсний аудитын газар	1	-	-	0.0	-	-	1
20	Үндэсний хөгжлийн газар	1	31.8	30.0	70.0	-	1	-
21	Монголбанк	3	90.0	90.0	73.3	2	1	-

* Бүрэн хэрэгжсэн 90-100 хувь, **Хэрэгжилт дутуу 30-89 хувь, ***Хэрэгжээгүй 30 хувиас доош.

2.6 Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагуудаас ЗТХЯ, БОАЖЯ, ХЗДХЯ, ЭХЯ, ХХААХҮЯ, ХХМТГ, СЗХ-ны хариуцан хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

2.7 Үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээгүй, дутуу хэрэгжүүлсэн шалтгааны ангиллыг графикаар харуулбал,

График 2



Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зарим яам, агентлаг үр дүнтэй зохион байгуулаагүй байна

2.8 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хариуцсан яам, агентлагаас зохион байгуулсан ажил хангалтгүй, хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас зарим арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- 2.7 “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг жигдрүүлж, эдийн засгийг дэмжих” /Сангийн яам/ 50 хувь,
- 3.2 “Гадаад худалдааг хөнгөвчлөх “Цахим нэг цонх” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх” /ГХЯ/ 0 хувь,
- 4.4 “Улсын тусгай хэрэгцээнд авах отрын бэлчээрийн талбайн ашиглалтыг сайжруулах, аймаг дундын болон сум дундын отрын бүсийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” /ХХААХҮЯ/ 50 хувь,
- 5.2 “Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх” /УУХҮЯ/ 10 хувь,
- 13.8 “Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих” /БОАЖЯ/ 30 хувь,
- 19.2 “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн шаталсан хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэх /ХНХЯ/ 10 хувь,
- 20.9 “Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг боловсронгуй болгох” /Сангийн яам/ 50 хувь,
- 20.11 “Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа шүүх, прокурорын барилгын санхүүжилтийг шийдвэрлэх 2016 оны төсөвт тусгах” /ХЗДХЯ/ 30 хувь байна.

2.9 Үндсэн чиглэлд туссан зарим арга хэмжээ цаг хугацааны хувьд нэг жилд хэрэгжүүлэх боломжгүйгээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй болсон байна. Тухайлбал,

- 2.5 “Тавантолгойн төслийг үргэлжлүүлэх” /УУХҮЯ/ 50 хувь,
- 2.6 “Үндэсний давхар даатгалын корпорацитай байгуулах” /Сангийн яам/ 50 хувь,
- 13.7 “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц, үр дүнтэй арга хэмжээ авах” /БОАЖЯ/ 50 хувь,
- 21.2 “Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах” /ГХЯ/ 30 хувь,
- 21.3 “Зүүн Азийн дээд түвшний уулзалтын гишүүн улс болох чиглэлээр ажиллах” /ГХЯ/ 30 хувьтай байна.

2.10 Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын саналыг авалгүйгээр баталсан, бэлтгэл ажил хангагдаагүй, хөрөнгө санхүүгийн тооцоо судалгаа дутуу хийгдсэнээс дараах зорилт, арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн байна. Үүнд:

- 5.8 “Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх” /ЭХЯ/ 50 хувь,
- 7.9 “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх” /ЭХЯ/ 50 хувь,
- 7.11 “БНХАУ-тай Эрчим хүчний ерөнхий хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлэх” /ЭХЯ/ 50 хувь,
- 13.5 “Туул усан цогцолбор, Орхоны шинэ нуур, Шүрэнгийн УЦС-ын ажлын зураг төслийг боловсруулах” /БОАЖЯ/ 10 хувь байна.

Үндсэн чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлсэн хөрөнгө нь зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрэлцээгүй байна

2.11 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд нийт 3,852.3 тэрбум төгрөг төлөвлөгдснөөс урьдчилсан гүйцэтгэлээр 416.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Хүснэгтээр харуулбал,

Д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Санхүүжилт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Улсын төсөв	233.9	202.5
2	Орон нутгийн төсөв	0.7	-
3	ТХХТ	3,189.0	-
4	ХЭДС	7.0	19.7
5	Хөгжлийн банк	110.0	68.7
6	Хувийн хэвшил	2.5	1.0
7	Гадаад эх үүсвэр	278.0	72.1
8	Холимог эх үүсвэр*	31.2	48.09
9	Бусад	-	4.1
	Нийт дүн /төгрөгөөр/	3,852.3	416.2

* Хувийн хэвшил болон гадаад эх үүсвэрээс 14.0 тэрбум, Хөгжлийн банк болон гадаад эх үүсвэрээс 15.7 тэрбум, Улсын төсөв болон гадаад эх үүсвэрээс 1.5 тэрбум.

2.12 Үндсэн чиглэлийн арга хэмжээнд урьдчилсан гүйцэтгэлээр нийт 416.2 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 9 дахин бага гүйцэтгэлтэй бөгөөд зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгө хүрэлцээгүйг харуулж байна. Зарим томоохон арга хэмжээнээс дурдвал,

Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 6.1 “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв байгуулах” /ХХААХҮЯ/ 5.0 тэрбум төгрөг,
- 7.1 “Чойрын дэд станцыг өргөтгөж, Багануур-Өндөрхаан-Чойбалсан, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 2 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ, дэд станц, Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцыг барих ажлын бэлтгэлийг хангах” /ЭХЯ/ 5.0 тэрбум төгрөг,
- 7.2 “ДЦС-5”-ын барилгын ажил, Сонгино дэд станц хүртэлх 220 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг эхлүүлж, дулаан дамжуулах магистраль шугамын зураг, төслийг боловсруулах” /ЭХЯ/ 150.0 сая ам.доллар,
- 8.5 “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэх” /ЗТХЯ/ 600.0 сая ам.доллар,
- 8.6 “Эрдэнэт-Овоотын 3 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлүүлэхэд” 131.0 сая ам доллар,
- 9.2. “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын нөөцийн агуулах барихад дэмжлэг үзүүлэх” /УУХҮЯ/ 19.0 тэрбум төгрөг,
- 12.1 “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлэх” /ХХААХҮЯ/ 40.0 тэрбум төгрөг,
- 13.2 “Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч, түүхий эд үйлдвэрлэх эко цогцолбор” /БОАЖЯ/ 300.0 тэрбум төгрөг,
- 15.5 “Багануур дахь их сургуулиудын хотхоны дэд бүтэц, барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх” /БСШУСЯ/ 5.0 тэрбум.

Улсын төсвөөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 11.1 “Төв аймгийн Хөшигийн хөндийн шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” /БХБЯ/ 0.3 тэрбум төгрөг,
- 20.5 “Төрийн аудитын чанарыг сайжруулж, үйлчилгээг ил тод хүртээмжтэй болгох” /ҮАГ/ 1.0 тэрбум төгрөг,
- 21.6 “Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим виз олгох ажлыг эхлүүлэх” /ГХЯ/ 0.5 тэрбум төгрөг.

Гадаад эх үүсвэрээр хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 7.4 “Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт-аар нэмэгдүүлэх” /ЭХЯ/ 42.0 сая ам.доллар,
- 15.8 “Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын орчинд үнэлгээ хийж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгох” /БСШУСЯ/ 0.5 тэрбум төгрөг,
- 20.3 “Аймгуудын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах” /ХЗДХЯ/ 15.0 тэрбум төгрөг гэх мэт.

2.13 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд 3.1 их наяд төгрөгийг ТХХТ-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

2.14 Үндсэн чиглэлийг УИХ болон байнгын хороодоор хэлэлцэх явцад нэмэгдсэн дараах арга хэмжээ хэрэгжээгүй, дутуу хэрэгжсэн нь хөрөнгийн үндэслэл тооцоог бодитой хийгээгүй, судалгаа хангалтгүйгээс шалтгаалсан байна. Үүнд:

- 2.11 “Үйлдвэрлэлийн орц болох эрчим хүч, материал, усыг үр ашигтай хэмнэлттэй болгох төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх” 0 хувь,
- 5.8 “Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох ажлыг эхлүүлэх” 50 хувь,
- 7.9 “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилтийг шийдвэрлэх” 50 хувь,
- 7.11 “БНХАУ-тай Эрчим хүчний ерөнхий хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлэх” 50 хувь,
- 12.6. “Хоршоодыг дэмжиж бүх сумдад мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгох” 10 хувь,
- 13.8 “Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих” 30 хувь,

- 16.9 “Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тухай хууль гаргаж, төр, гэр бүл, иргэн бүрийн үүрэг хариуцлагыг сайжруулах” 50 хувь,
- 20.9 “Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан ТБОНӨХБАҮХАТХ-ийг боловсронгуй болгох” 50 хувьтай байна.

Зарим зорилт, арга хэмжээний өмнөх онуудад зарцуулсан хөрөнгө үр дүнгүй байна

2.15 Өмнөх онуудаас дамжин жил бүр хэрэгжүүлэхээр тусгагдсан зарим зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулсан төсвийн хөрөнгө төлөвлөлтийн алдаа болон бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан үр ашиггүй зарцуулагдсан байна. Тухайлбал,

- 5.1 “Газрын тос боловсруулах үйлдвэр барих, ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах” арга хэмжээний хүрээнд 2013 онд Дархан-Уул аймагт байгуулахаар болж 1,450.0 сая төгрөгөөр ГТБҮ-ийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан боловч Засгийн газрын 2015 оны 113 дугаар тогтоолоор байршил өөрчлөгдөж дахин боловсруулахаар ажиллаж байна.
- 5.2 “Зэс хайлуулах үйлдвэр барих, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх” арга хэмжээний хүрээнд 2015 онд “Эрдэнэт үйлдвэр” ХХК нарийвчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан боловч Засгийн газрын 2016 оны 318 дугаар тогтоолоор байршил өөрчлөгдөж Оюутолгойд барихаар болсон.
- 15.5 “Багануур дахь их сургуулиудын хотхоны дэд бүтэц, барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх” арга хэмжээ 2012 оноос хойш үргэлжилж, 2016 онд урсгал зардалд 226.3 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

2.16 Хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн зорилт, арга хэмжээний хувь хэмжээ өссөөр байгаа нь төлөвлөлт бодитой бус, зорилт, арга хэмжээнд хөрөнгө хүрэлцээгүй, зохион байгуулсан ажлын үр дүн хангалтгүй байгаатай холбоотой байна.

Бүлэг 3. Зарим хариуцан хэрэгжүүлэгч байгууллага үндсэн чиглэлийн арга хэмжээг бодитой үнэлж, тайлагнаагүй байна

3.1 Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан журмын 18⁴-д заасны дагуу хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ үнэлгээний холбогдох заалтыг баримтлаагүй байна

3.2 Засгийн газрын 322 дугаар тогтоолоор батлагдсан Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмын 25.2⁵, 52⁶-т заасны дагуу хэрэгжилтийг үнэлэхдээ дараах хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд холбогдох заалтыг баримтлаагүй байна. Тухайлбал,

- БОАЖЯ хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээг нэгтгэн дүгнэж 2.0 пунктээр өсгөж 80.8 хувиар,
- УУХҮЯ хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээг нэгтгэн дүгнэж 2.5 пунктээр өсгөж 84.2 хувиар,
- ХХААХҮЯ хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээг нэгтгэн дүгнэж 8.7 пунктээр өсгөж 76.7 хувиар,
- БХБЯ 1 арга хэмжээг үнэлэхгүйгээр нэгтгэн дүгнэж 19.5 пунктээр өсгөж 87.5 хувиар үнэлсэн байна.

3.3 Зарим яамдын ХШҮДАХ зорилт, арга хэмжээний биелэлтийг 30-аас доош хувийн хэрэгжилттэй байхад 70-100 хувиар үнэлсэн байна. Тухайлбал,

- 5.2 “Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх” 70 хувь, /УУХҮЯ/
- 5.7 “Цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар харилцагч талтай хэлэлцээр хийх, бодлогыг Улсын Их Хуралд танилцуулах” 90 хувь, /УУХҮЯ/
- 13.6 “Гидрогеологийн зураглал, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул, судалгаа хийх” 100 хувь, /БОАЖЯ/
- 13.8 “Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих” 90 хувь, /БОАЖЯ/
- 16.5 “Сонгинохайрхан дүүрэгт загвар нэгдсэн эмнэлэг барих ажлыг эхлүүлэх” 100 хувь, /ЭМЯ/
- 18.1 “Ажил олгогчидтой хамтран хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжлийн хэрэгцээг тодорхойлох, тэдгээрт нийцүүлэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн ур чадвар олгох үйлдвэрлэл дээрх сургалтыг өргөжүүлэх” 100 хувь, /ХНХЯ/
- 20.10 “Архивын шинэ барилга, Төрийн албан хаагчийн нэгдсэн эмнэлэгийн тоног төхөөрөмжийн зардал, түүнчлэн шинээр баригдаж байгаа хорих ангийн барилгын санхүүжилтийг шийдвэрлэх” 80 хувь, /ХЗДХЯ/
- 20.11 “Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа шүүх, прокурорын барилгын санхүүжилтийг шийдвэрлэх” 80 хувь, /ХЗДХЯ/
- 21.2 “Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах” 100 хувь, /ГХЯ/

⁴ Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг Эдийн засгийн хөгжлийн яаманд, үндэсний хөтөлбөр, төслийн биелэлтийн тайланг тухайн хөтөлбөр, төсөл хэрэгжиж байгаа салбарын яаманд хүргүүлэх бөгөөд яам нь тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

⁵ Хэд хэдэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, байгууллагад өгсөн үүрэг, даалгавар, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эхэнд нэр нь бичигдсэн Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, Засаг дарга толгойлон зохион байгуулж, хэрэгжилтийг нэгтгэн мэдээлнэ;

⁶ Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ нь үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн түвшин (хувь)-ий нийлбэрийг нийт үзүүлэлтийн тоонд хувааж гаргасан дундаж хувиар илэрхийлэгдэнэ.

- 21.3 “Зүүн Азийн дээд түвшний уулзалтын гишүүн улс болох чиглэлээр ажиллах” 80 хувь, /ГХЯ/
- 21.6 “Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим виз олгох ажлыг эхлүүлэх” 90 хувь, /ГХЯ/ гэж үнэлжээ.

3.4 Сангийн яам, ЗТХЯ, ЭХЯ, БСШУСЯ, ҮАГ, ҮХГ-ууд зорилт, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөхдөө Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх нийтлэг журмын 337-т заасныг баримтлаагүй байна.

3.5 Түүнчлэн зарим яамдын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үр дүнд чиглүүлэн бодитой үнэлэх асуудал учир дутагдалтай байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна

3.6 Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дутуу хэрэгжилттэй болон хэрэгжээгүй 35 арга хэмжээг 2016 онд хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлсэн.

3.7 Зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзэхэд санхүүжилт хүрэлцээгүй, хариуцан болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын ажлын зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 23 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Тухайлбал,

2016 онд дахин батлагдсан боловч хэрэгжээгүй арга хэмжээ:

- 8.5 “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэх” /ЗТХЯ/,
- 8.7 “Мандалговь-Багахангай чиглэлийн Богдхан төмөр замын суурь бүтцийг барих ажлыг эхлүүлэх” /ЗТХЯ/,
- 12.5 “Харилцаа холбооны үндсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох” /ХХМТГ/.

2015 оны үндсэн чиглэлийн хэрэгжээгүй арга хэмжээ:

- 8.6 “Замын-Үүд суманд холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах” /ЗТХЯ/,
- 9.2 “Экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн биржийн эрх зүйн орчныг бүрдүүлэх” /ГХЯ/,
- 9.4 “Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх /УУХҮЯ/,
- 9.5 “Нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж эхлэх” /УУХҮЯ/,
- 20.6 “Архигүй Монгол хүн” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх” /ХЗЯ/ гэх мэт.

3.8 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх нь үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг бодитой төлөвлөх, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оновчтой тогтооход түлхэц болох бөгөөд цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй байна.

3.9 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж тайлагнахдаа зарим ТЭЗ болон хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд холбогдох журмыг баримтлаагүй, хэрэгжилтэд тавих хяналт сул байгаа нь тайлагналын чанарт сөргөөр нөлөөлсөн байна.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Үндсэн чиглэлийн зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцож, төлөвлөөгүй байна.
- Үндсэн чиглэлд цаг хугацааны хувьд нэг жилд хэрэгжүүлэх боломжгүй, бэлтгэл ажил хангагдаагүй, тооцоо судалгаа дутуу зорилт, арга хэмжээ төлөвлөгдсөн нь гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна.
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хариуцан хэрэгжүүлэгч байгууллагаас зохион байгуулсан ажлын үр дүн хангалтгүй байна.
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй, санхүүжилт бүрэн хийгдээгүй байна.
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг холбогдох журмын дагуу үнэлэх, тайлагнах талаар хангалтгүй ажилласан байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Төсвийн ерөнхийлөн захирагчдын зохион байгуулсан ажил хангалтгүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдад:

- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг бодитой тогтоож байх,
- Зорилт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, хамтран хэрэгжүүлж байгаа бусад яамд болон байгууллагуудтай ажлын уялдааг хангаж ажиллах,
- Үндсэн чиглэлийн биелэлтийг холбогдох журмын дагуу зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлттэй нь уялдуулан тухайн жилд хийсэн ажлын гүйцэтгэлд зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой тусгаж бодитой тайлагнаж байх.

Сангийн яаманд:

- Үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай улсын төсөв болон бусад эх үүсвэрийн тооцоог бодитой хийх,
- Үндсэн чиглэлийн биелэлтэд дүгнэлт хийж, дараа жилийн үндсэн чиглэлийн төлөвлөгөөг боловсруулахад ашиглаж байх.


Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газарт:

- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох,
- Үндсэн чиглэлд хийсэн аудитын тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчдад хүргүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах.

Улсын Их Хуралд толилуулах нь:

- Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд ТЭЗҮ батлагдаагүй, бусад бэлтгэл ажил хангагдаагүй, хөрөнгийн эх үүсвэр нь тодорхой бус зорилт арга хэмжээг нэмж батлахгүй байх талаар анхаарна уу.

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:


МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>


2017.03.27 № 5-2/11644
танай 2017.03.20-ны № 493 -Т


ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж холбогдох саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 1 хуудас.

Хүндэтгэсэн,


ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ТӨСВИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА **Ж.ГАНБАТ**



Тайлбар 1-ийг үзнэ үү.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

Тайлбар 3-ыг үзнэ үү.

Тайлбар 4-ийг үзнэ үү.

Тайлбар 5-ыг үзнэ үү.

Тайлбар 6-г үзнэ үү

Саналд өгсөн тайлбар:

Тайлбар 1 - Холбогдох засварыг хийв.

Тайлбар 2 - Саналын дагуу нягталж үзэв.

Тайлбар 3 - Саналын дагуу нягталж үзэн 2.8, 5.8 гэсэн зорилт, арга хэмжээг энэ хэсгээс хасав.

Тайлбар 4 - Өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Тайлбар 5 - Өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Тайлбар 6 - Саналыг хүлээн авч зөвлөмжийн энэ хэсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчдад хариуцуулахаар засав.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт"-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор /М.Давааням/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Khereg\Tushaal\2017\0330GAG6.Docx

070414

Үндсэн чиглэлийн дутуу хэрэгжсэн зорилт, арга хэмжээний жагсаалт

Д/д	Бодлогын, зорилт арга хэмжээ	ҮАГ-ын үнэлгээ	Хэрэгжүүлэгч байгууллага
1	13.6 Гидрогеологийн зураглал, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул, судалгаа хийх	30	БОАЖЯ
2	13.7 Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц, үр дүнтэй арга хэмжээ авах	50	
3	13.8 Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих	30	
4	10.1 Шинжлэх ухаан, технологийн эрх зүйн орчныг сайжруулах	60	БСШУСЯ
5	15.1 Ерөнхий боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	80	
6	15.2 Ерөнхий боловсролын сургуулийн I- V болон X-XII ангийн сурах бичгийн агуулга, стандартыг шинэчилж, нөхөн хангалт хийх	70	
7	15.3 Багш, инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	30	
8	15.4 Инженер, технологийн дээд боловсрол төслийн хүрээнд судлаач, оюутныг сургалтад хамруулах	80	
9	15.6 "Дээд боловсролын шинэчлэл" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	80	
10	15.7 Дэлхийн шилдэг сургуулиудад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт оюутан суралцуулж, өрсөлдөх чадвартай монгол хүнийг хөгжүүлэх	80	
11	15.8 Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын орчинд үнэлгээ хийж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгох	60	
12	15.9 Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх	50	
13	17.1 Бүх нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн, наадмын зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох	80	
14	17.2 Хүүхэд, залуучуудад зориулсан спорт үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах	60	
15	17.4 Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх	30	
16	3.1 Тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, хөрш болон гуравдагч орны зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр бараа, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлэх	80	
17	21.2 Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах	30	
18	21.3 Зүүн Азийн дээд түвшний уулзалтын гишүүн улс болох чиглэлээр ажиллах	30	ЗТХЯ
19	21.6 Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим виз олгох ажлыг эхлүүлэх	50	
20	8.3 Аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох	50	
21	1.1 Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах	70	Сангийн яам
22	1.7 Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх	30	
23	2.3 Засгийн газрын өрийн баталгааны сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг эхлүүлэх	70	
24	2.6 Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах	50	
25	2.7 Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг жигдрүүлж, эдийн засгийг дэмжих	50	
26	20.4 Төрөөс худалдан авах ажиллагааны талаар баримтлах бодлогын цогц баримт бичиг боловсруулах, эрх зүйн орчныг сайжруулах	30	
27	20.9 Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг боловсронгуй болгох	50	
28	2.4 Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	30	УУХҮЯ
29	2.5 Таван толгойн төслийг үргэлжлүүлэх	50	
30	5.3 Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, хуурай аргаар боловсруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжих	70	
31	9.1 Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх	86.5	ХЗДХЯ
32	9.2 Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын нөөцийн агуулах барихад дэмжлэг үзүүлэх	50	
33	9.4 Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж, мөрдүүлэх	70	
34	20.10 Архивын шинэ барилга, Төрийн албан хаагчийн нэгдсэн эмнэлэгийн тоног төхөөрөмжийн зардал, түүнчлэн шинээр баригдаж байгаа хорих ангийн барилгын санхүүжилтийг шийдвэрлэх	30	
35	20.11 Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа шүүх, прокурорын барилгын санхүүжилтийг шийдвэрлэх 2016 оны төсөвт тусгах	30	ХНХЯ
36	20.3 Аймгуудын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах	30	
37	22.3 Монгол-Оросын хилийн дэглэмийн гэрээ, улсын хилийг хамтран шалгасан протоколын дагуу Монгол-Оросын хилийн багана, тэмдгийг засварлах	80	
38	1.2 Ажлын байрыг хадгалах зарчим баримталж, ажилгүйдлийн түвшинг бууруулах	70	ХНХЯ
39	15.12 Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогыг шинэчилж, залуучуудын асуудлыг гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүд, хүн амын хөгжлийн бодлоготой уялдуулах	70	
40	18.1 Ажил олгогчидтой хамтран хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжлийн хэрэгцээг тодорхойлох, тэдгээрт нийцүүлэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн үр чадвар олгох үйлдвэрлэл дээрх сургалтыг өргөжүүлэх	50	
41	18.3 Ажилд зуучлах, зөвлөл бэлтгэх, мэргэшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцоог сайжруулах	70	
42	18.5 Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх асуудлыг улсын төсвийн боломжтой уялдуулан судалж, шийдвэрлэх	70	
43	18.6 Хувь хүний албан татвар тооцох орлогоос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү хэмжээгээр хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	70	

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт

44	18.7	Гадаадаас ажиллах хүч авах тогтолцоог боловсронгуй болгож, ажиллах хүчинд тавигдах шаардлагыг сайжруулж, зуучлалын үйл ажиллагааг эрхлэх байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах	70	
45	18.8	Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	50	
46	18.9	Мэргэжлийн боловсрол, сургалтын тэргүүлэх чиглэлийг тогтоох замаар төрөлжүүлэх бодлогыг боловсруулах	30	
47	19.2	“Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн шаталсан хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэх	30	
48	19.7	“Олон хүүхэд төрүүлсэн эх, олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	70	
49	4.4	Улсын тусгай хэрэгцээнд авах отрын бэлчээрийн талбайн ашиглалтыг сайжруулах, аймаг дундын болон сум дундын отрын бүсийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	50	
50	12.1	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлэх	30	
51	12.3	Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлөө бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ХАА-н биржийн арилжаан дахь оролцоог нэмэгдүүлэх	30	
52	12.7	Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээр сэргээх, малын тэжээл бэлтгэх иргэдийн санаачилгыг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	80	
53	4.2	Төв, суурин газрын ойролцоо мах, сүүний чиглэлийн хонь, үхрийн болон гахай, шувууны фермерийн аж ахуй байгуулж, дотоодын хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	70	ХХААХҮЯ
54	4.7	Чихрийн манжин тариалж, элсэн чихэр үйлдвэрлэх, чацаргана болон бусад жимсний тариалалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжих	70	
55	5.4	Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	60	
56	5.5	Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох	70	
57	16.1	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, стандартыг дээшлүүлж, ажиллагчдын ёс зүй, хариуцлагыг сайжруулах	80	
58	16.5	Сонгинохайрхан дүүрэгт загвар нэгдсэн эмнэлэг барих ажлыг эхлүүлэх	30	
59	16.8	Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд тогтмол хугацаанд хамруулах	70	ЭМЯ
60	16.9	Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тухай хууль гаргаж, төр, гэр бүл, иргэн бүрийн үүрэг хариуцлагыг сайжруулах	50	
61	5.8	Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх	50	
62	7.1	Чойрын дэд станцыг өргөтгөж, Багануур-Өндөрхаан-Чойбалсан, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 2 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ, дэд станц, Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцыг барих ажлын бэлтгэлийг хангах	30	
63	7.11	БНХАУ-тай Эрчим хүчний ерөнхий хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлэх	50	ЭХЯ
64	7.3	Бүс нутгийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах хүрээнд Баруун болон Дорнод бүсийн ДЦС, Тавантолгой, Багануур, Тэлмэн, Баянтээгийн ДЦС-уудын барилгын ажлыг эхлүүлэх	70	
65	7.5	Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хангах зорилгоор Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх	50	
66	7.9	Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх	50	
67	2.9	Банкны салбарт эрсдэл хуримтлагдах, зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авах	30	Монголбанк
68	14.1	Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	70	ОБЕГ
69	2.10	Нийгмийн даатгалын зарим төрлийг хувийн амьдралын даатгалд шилжүүлэх замаар урт хугацааны болон хувийн тэтгэврийн даатгалын зах зээлийг хөгжүүлэх	50	СЗХ
70	2.1	Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх	70	ҮХГ
71	10.3	Монгол Улсын насанд хүрсэн иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагч нарт цахим гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлэх	30	ХХМТГ
72	3.3	“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг барьж байгуулах	70	ШСАА

Үндсэн чиглэлийн хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний жагсаалт

	Д/д	Бодлогын, зорилт арга хэмжээ	Хэрэгжүүлэгч байгууллага
1	13.2	Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч, түүхий эд үйлдвэрлэх эко цогцолбор байгуулах	БОАЖЯ
2	13.5	Туул усан цогцолбор, Орхоны шинэ нуур, Шүрэнгийн УЦС-ын ажлын зураг төслийг боловсруулах	
3	15.5	Багануур дахь их сургуулиудын хотхоны дэд бүтэц, барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	БСШУСЯ
4	17.3	Төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын түншлэлийг хөгжүүлэх замаар биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн бүх шатны магадлан итгэмжлэлийг эхлүүлэх	
5	11.1	Төв аймгийн Хөшигийн хөндийн шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	БХБЯ
6	3.4	Гадаад худалдааг хөнгөвчлөх "Цахим нэг цонх" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	ГХЯ
7	8.1	Нийтийн тээврийн үйлчилгээнд тусгай замын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх төслийг эхлүүлэх	ЗТХЯ
8	8.2	Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж ашиглалтад оруулах	
9	8.5	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	ЗТХЯ
10	8.6	Эрдэнэт-Овоотын 3 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлүүлэх	
11	8.7	Мандалговь-Багахангай чиглэлийн Богдхан төмөр замын суурь бүтцийг барих ажлыг эхлүүлэх	
12	8.8	Даланзадгад Ховдын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгон өргөжүүлэх	
13	8.9	Ховдоос Завхан чиглэлийн Сархайрханы гүүр хүртэлх 130 км хатуу хучилттай авто замыг барих асуудлыг судлаж шийдвэрлэх	УУХҮЯ
14	5.2	Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх	
15	5.7	Цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар харилцагч талтай хэлэлцээр хийх, бодлогыг Улсын Их Хуралд танилцуулах	ҮАГ
16	20.5	Төрийн аудитын чанарыг сайжруулж, үйлчилгээг ил тод хүртээмжтэй болгох	
17	20.12	Гэрч, хохирогчийг хамгаалах, Тахарын албыг бэхжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт" гэсэн заалтыг 2016-2018 оны төсвүүдэд тусгайлан тусгах	ХЗДХЯ
18	20.2	Гадаад орнуудын архивт хадгалагдаж байгаа Монгол Улсын түүх соёлтой холбогдох баримтыг илрүүлэх, тэдгээрийг хуулбарлах, худалдан авах замаар сан хөмрөгийг баяжуулах	
19	19.3	Хүүхэд хамгааллын тусламжийн цогц, шуурхай үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн тусламжийн утсанд ирсэн дуудлагаас шууд яаралтай тусламж үзүүлэх, хариу арга хэмжээ авах	ХНХЯ
20	19.5	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд ахмадуудыг зуучлан хамруулах, богиносгосон цагаар ажиллах боломжийг бүрдүүлэх	
21	12.4	Хүлэмжийн аж ахуйн тоо, хэмжээг нэмэгдүүлж, таримлын нэр төрлийг олшруулах	ХХААХҮЯ
22	12.6	Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг хөгжүүлэх хүрээнд хоршоодыг дэмжиж бүх сумдад мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгох	
23	2.11	Үйлдвэрлэлийн орц болох эрчим хүч, материал, усыг үр ашигтай хэмнэлттэй болгох төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	
24	2.8	Тоног, төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих;	
25	5.6	Хоногт 2-5 тонн сүү хөргөх хүчин чадалтай хөргөлтийн төвүүдийг байгуулах	
26	6.1	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв байгуулах	
27	12.5	Харилцаа холбооны үндсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох	ХХМТГ
28	20.6	Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор нээлттэй ухаалаг төрийн удирдлагын системийг нэвтрүүлэх	
29	7.2	"ДЦС-5"-барилгын ажил, Сонгино дэд станц хүртэлх 220 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг эхлүүлж, дулаан дамжуулах магистраль шугамын зураг, төслийг боловсруулах	ЭХЯ
30	7.4	Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт-аар нэмэгдүүлэх	
31	7.8	Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгийн төвүүдэд дулаан хангамжийн шинэ эх үүсвэр барих"	

the 1990s, the number of people with a mental health problem has increased in the UK, and the number of people with a mental health problem who are in contact with mental health services has also increased (Mental Health Act 1983, 1990).

There is a growing awareness of the need to improve the lives of people with a mental health problem, and to reduce the stigma and discrimination that they experience (Mental Health Act 1983, 1990).

The aim of this study was to explore the experiences of people with a mental health problem who are in contact with mental health services, and to identify the factors that influence their experiences.

Method

Design

This was a qualitative study, using semi-structured interviews to explore the experiences of people with a mental health problem who are in contact with mental health services.

The study was conducted in a mental health service in the north of England, which provides a range of services for people with a mental health problem, including inpatient care, day care, and community care.

The study was approved by the local research ethics committee, and all participants gave their informed consent.

Participants

Participants were recruited through a range of sources, including mental health services, community groups, and the media. A total of 15 people with a mental health problem who were in contact with mental health services participated in the study.

The participants were interviewed in a range of settings, including their homes, a community centre, and a mental health service. The interviews were conducted by a research fellow who had experience of conducting qualitative research and was not involved in the provision of mental health services.

Interviews

The interviews were semi-structured, and lasted between 30 and 60 minutes. The interviews explored the following issues:

• The participant's experience of having a mental health problem.

• The participant's experience of being in contact with mental health services.

• The factors that influence the participant's experience.

Results

The results of the study are presented in a range of ways, including text, tables, and diagrams. The following table provides a summary of the key findings of the study.